



ГАДААД ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2024 оны 8 сарын 14-ний байдлаар



ТОВЧ АГУУЛГА

- Олон улсын хүнсний үнийн индекс сүүлийн 2 орчим жил буурах хандлагатай байгаа ч цар тахлын өмнөх үеэс өндөр хэвээр байна.
- Алт, газрын тос, нүүрсний үнэ харьцангуй тогтвортой байгаа бол зэс, төмрийн хүдрийн үнэ буурах хандлагатай байна.

**1 Төв банкуудын бодлогын шийдвэр**

Холбооны нөөцийн банк (ХНБ) 2024 оны 7-р сарын 31-ний өдрийн хурлаар бодлогын хүүгээ 5.25-5.5 хувийн интервалд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. АНУ-ын инфляц энэ оны 3-р сард 3.5 хувьд хүрч нэмэгдээд байсан ч түүнээс хойш буурсаар 6-р сард 3.0 хувьд болов. ХНБ ирэх 9 сард болох хурлаар бодлогын хүүгээ бууруулах боломжтой талаар шинжээчид таамаг дэвшүүлээд байна.

Европын төв банк (ЕТБ)-ны удирдах зөвлөлийн 2024 оны 7-р сарын 17-ны өдрийн хурлаар шинжээчдийн хүлээлтийн дагуу бодлогын хүүгээ хэвээр хадгалах шийдвэр гаргав. Өмнө нь 2024 оны 6-р сарын эхэнд болсон хурлаар бодлогын хүүгээ 0.25 пунктээр бууруулсан юм. Евро бүсийн инфляц 6-р сард 2.5 хувь байгаа бол цаашид буурсаар 2025 оны төгсгөлд зорилт болох 2.0 хувийн түвшинд хүрэх тооцоотой байна.

БНХАУ-ын Ардын банк энэ оны 7-р сарын 22-нд бодлогын хүүгээ 0.1 нэгж хувиар бууруулав. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2-р улиралд 4.7 хувь буюу хүлээлтээс бага гарч, тус улс энэ жилийн 5 хувийн өсөлтийн зорилтдоо хүрэхэд хүндрэлтэй байгаа талаар олон улсын байгууллагуудын тайланд дурдаж байна. Харин энэ шийдвэрээс хэдхэн хоногийн өмнө болсон Хятадын Коммунист Намын 20 дахь удаагийн Төв хорооны гуравдугаар их хурлын үеэр энэ жилийн эдийн засгийн зорилтдоо хүрэх шаардлагатай байгааг онцолсон юм. Ийнхүү төв банкны зүгээс эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилготой гэнэтийн шийдвэр гаргалаа.

Английн төв банк 2024 оны 7-р сарын 31-ний хурлаар бодлогын хүүгээ 5.25 хувиас 5.0 хувь болгож бууруулав. Тус улсын инфляц 2024 оны 5 болон 6 саруудад 2.0 хувьтай буюу зорилтот түвшинд байсан нь ийнхүү хүүгээ бууруулах үндэслэл боллоо. Түүнчлэн, энэ шийдвэр нь 2020 оны 3-р сараас хойш хүүгээ бууруулж буй анхны тохиолдол юм. Шинжээчдийн зүгээс энэ оны үлдсэн хугацаанд Английн төв банк дахин нэг удаа хүүгээ бууруулах шийдвэр гаргах таамаг дэвшүүлээд байна.

ОХУ-ын төв банк 2024 оны 7-р сарын 26-ны шийдвэрээр бодлогын хүүгээ 2 нэгж хувиар нэмэгдүүлж 18.0 хувьд хүргэв. Өмнөх оны 11-р сараас хойш 7.0-8.0 хувьтай байсан инфляц энэ оны 6-р сард 8.6 хувь, 7-р сард 9.1 хувьд хүрч эрчимжсэн нь ийнхүү мөнгөний бодлогыг чангаруулах шалтгаан боллоо. Энэхүү инфляцын өсөлт нь нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсээс ихээхэн шалтгаалсан гэж ОХУ-ын төв банкны зүгээс мэдэгдлээ. Түүнчлэн, тус улсын иргэд, аж ахуйн нэгжүүдийн инфляцын хүлээлт нэмэгдээд байна.


Японы төв банк 2024 оны 7-р сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрээр 0-0.1 хувийн интервалд байсан богино хугацаат бодлогын хүүгээ 0.25 хувьд хүргэж нэмэгдүүлэв. Энэхүү бодлогын шийдвэр нь иений ам.долларын эсрэг ханшийн сулралтыг хязгаарлах зорилготой байв. Иений ханш сүүлийн жилүүдэд ам.долларын эсрэг ихээр суларч, 7-р сарын эхээр 1 ам.доллар 161 орчим иентэй тэнцэж байсан бол 8-р сар гарснаас хойш 150-иас доош орж чангараад байна. Тус улсын инфляц энэ оны төгсгөлд 2.5 хувь, ирэх жил зорилтот 2.0 хувийн орчимд байх төсөөллийг төв банкнаас гаргажээ. Мөн цаашид Японы Засгийн газрын бондын худалдан авалтаа бууруулахаа мэдэгдлээ. Японы төв банкны хувьд одоогийн байдлаар Засгийн газрынхаа нийт бондны ойролцоогоор тал хувийг нь эзэмшиж байна.



2 Дэлхийн хүнсний үнэ

НҮБ-ын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-аас гаргадаг дэлхийн хүнсний үнийн индекс 2024 оны 7-р сарын байдлаар 120.8 буюу 2 жилийн өмнөх оргил үеэс 24.7 хувиар, жилийн өмнөхөөс 3.1 хувиар тус тус буурсан байна (Зураг 1). Жилийн өөрчлөлтөөр нь харвал сүүлийн 20 сар дараалан тус индекс буурахад үр тарианы үнийн бууралт голчлон нөлөөлжээ.


Зураг 1. Дэлхийн хүнсний үнийн индекс, бүтээгдэхүүний төрлөөр, 2014-2016 = 100



Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг бүрийн ард ерөнхий индекст эзлэх жинг бичив.

Эх сурвалж: НҮБ-ын дэргэдэх ХХААБ

Зураг 2. Хүнсний үнийн индексийн жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Тайлбар: Бүрэлдэхүүн бүрийн жинг ашиглаж ерөнхий индексийг тооцоход үүссэн зөрүүг тооцооллын зөрүү хэсэгт оруулсан болно.

Эх сурвалж: FAO, судлаачийн тооцоолол

Бүтээгдэхүүн тус бүрээр үнийн өөрчлөлтийг дэлгэрүүлж тайлбарлавал:

- **Махны үнийн индекс (35%)** өмнөх сараас 1.2 хувиар, жилийн өмнөх үеэс 0.8 хувиар нэмэгдэв. Эрэлт тогтвортой үед улирлын чанартайгаар үхэр, хонины махны нийлүүлэлт буурсан нь энэ төрлийн махны үнэ нэмэгдэх шалтгаан боллоо. Африк дахь шувууны аж ахуйн гол бүс нутгуудад шувууны ханиад дэгдсэнээс шалтгаалж шувууны махны үнэ өсөв. Харин баруун Европт гадаад болон дотоод дахь гахайн махны эрэлт буурсан нь гахайн махны нийлүүлэлтийн илүүдлийг бий болгож, улмаар гахайн махын үнэ буурав. Тодруулбал, гахайн мялзан өвчин дэгдсэнтэй холбоотойгоор БНХАУ-ын зүгээс гадны улсаас гахайн мах худалдан авахыг хязгаарлаад байгаа нь гахайн махны эрэлт буурахад нөлөөлөв.
- **Үр тарианы үнийн индекс (27%)** 2024 оны 7-р сард 110.8 байгаа нь өмнөх сараас 4.4 хувиар, жилийн өмнөх үеэс 12.0 хувиар бага дүн юм. Улирлын чанартайгаар дэлхийн бөмбөрцгийн хойд талын бүс нутагт ургац хураалт үргэлжилж, улмаар үр тарианы нийлүүлэлт өссөн нь улс орнуудын үр тариа экспортлох өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн сацуу эрэлт сул байгаа тул ийнхүү үнэ буурав.
- **Сүү, сүүн бүтээгдэхүүний үнийн индекс (17%)** өмнөх сараас өөрчлөлтгүй ч жилийн өмнөх үеэс 7.2 хувиар өндөр байна. Хэдийгээр цөцгийн тос болон бяслагны үнэ өмнөх сараас нэмэгдсэн боловч хуурай сүүний үнэ буурсан нь үнийн өөрчлөлтгүй байх шалтгаан болов. Улирлын чанартайгаар Номхон далайн арлуудын сүүний үйлдвэрлэл буурч, агуулахын нөөц бага байсан боловч Баруун Европт зуны

улирлын нам гүм байдал үргэлжилж, хуурай сүүний эрэлт бага байсан нь ийнхүү хуурай сүүний үнэ буурах шалтгаан боллоо. Нөгөө талаас Баруун Европын дотоод дахь цөцгийн тос, бяслагны хэрэглээ өндөр байсан нь экспортын хүрэлцээг бууруулж, улмаар үнэ нэмэгдэхэд нөлөөлжээ.

- **Тос, тосон бүтээгдэхүүний үнийн индекс** (14%) өмнөх сараас 2.4 хувиар жилийн өмнөх үеэс 4.0 хувиар өндөр байна. Үүнд, далдуу модны тос, шар буурцгийн тос, рапсын тос, наран цэцгийн тосны үнэ өсөлттэй байна. Индонезын далдуу модны тосны үйлдвэрлэл потенциалгаас бага байгаа үед эрэлт өндөр байгаа нь энэ төрлийн тосны үнэ өсөх шалтгаан болж байна. Харин АНУ-ын биотүлшний сектор дахь шар буурцгийн тосны эрэлт тогтвортой сайн байгаа нь энэ төрлийн тосны үнэ 3 дахь сардаа дараалан өсөхөд нөлөөлөв. Наранцэцэгийн тос, рапсын тосны хувьд гол үйлдвэрлэгч бүс нутгуудад 2024/2025 оны тосны ургамлын ургац бага байх хүлээлт үүссэн нь үнэ нэмэгдэх шалтгаан боллоо.

Элсэн чихрийн үнийн индекс (7%) өмнөх сараас 0.7 хувиар нэмэгдсэн ч жилийн өмнөх үетэй харьцуулахад 17.9 хувиар доогуур байна. Сарын өмнөх үеэс үнэ нэмэгдэхэд Бразил дахь элсэн чихрийн нийлүүлэлт хүлээлтээс бага байсан нь нөлөөллөө. Нөгөө талаас Энэтхэг, Тайланд улсуудад цаг агаар тааламжтай байгаа нь элсэн чихрийн үнийг бууруулах чигт хөтөлж байна. Цаашид дээрх 2 улсын нөхцөл байдал үнийг бууруулах чигт нөлөөлсөн хэвээр байх бол Бразилд хуурай цаг агаар үргэлжилж, улмаар ургац буурах эрсдэлтэй байна. Эдгээр хүчин зүйлсийн аль нь давамгайлахаас хамаарч элсэн чихрийн үнэ цаашид өөрчлөгдөхөөр байна.



3 Түүхий эдийн үнэд гарсан өөрчлөлтийн тойм

Дараах хүснэгтэд манай улсын экспортын гол түүхий эдүүдийн үнэ хэрхэн өөрчлөгдөж байгааг 2024 оны 08-р сарын 9-ний өдрийн байдлаар харуулж, өөрчлөлтийн гол шалтгааныг тайлбарлалаа.

Хүснэгт 1. Экспортын гол нэрийн түүхий эдийн үнийн өөрчлөлт

Түүхий эдийн төрөл	Үнэ	Өөрчлөлт, %			
		7 хоног	Сар	оны эхнээс	жил
Зэс	8867 \$/тн	-0.3	-10.2	+3.8	+6.9
	Олон улсын зэсийн зах зээлд нам гүм байдал үргэлжилсээр байна. Дэлхийн зэсийн зах зээлийн тал хувийг бүрдүүлдэг БНХАУ-ын үл хөдлөх салбарын хямрал үргэлжилж, дотоодын эрэлт сул байгаагаас зэсийн илүүдэл үүсэж, улмаар хямд үнээр хайлуулсан зэсээ экспортолж байна.				
Алт	2431 \$/унци	+0.9	+2.8	+17.9	+27.0
	Хамас бүлэглэлийн удирдагч Исмаил Хания 2024 оны 7-р сарын 31-ний өдөр Ираны нийслэл Тегеранд байхдаа пуужинд өртөж нас барав. Үүнээс үүдэж Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөн ширүүсэх төлөвтэй болсон нь алтны үнэ нэмэгдэх шалтгаан боллоо. Нөгөө талаас АНУ-ын хөдөлмөрийн захын үзүүлэлт тааруу байгаа, ирэх 9-р сард ХНБ бодлогын хүүгээ бууруулах магадлал өндөр байгаа зэрэг нь алтны үнэ өсөхөд нөлөөлж байна.				
Газрын тос (Брент)	79.7 \$/бар	+2.4	-6.4	+5.0	-8.2
	Газрын тосны үнэ эсрэг чигт нөлөөлөх олон хүчин зүйлсийн нөлөөгөөр хэлбэлзэж байна. Эдгээрээс дурдвал Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөнд газрын тосны томоохон олборлогч Ираны оролцоо нэмэгдэхийн хэрээр үнэ өсөх эрсдэлтэй байгаа бол газрын тосны томоохон хэрэглэгч АНУ, БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил сулрах нь эрэлтийг бууруулж, улмаар үнэ буурах чигт нөлөөлж байна.				
Төмрийн хүдэр	94.4 \$/тн	-5.6	-7.4	-29.3	-10.2
	БНХАУ-д гангийн эрэлт бага байгаагаас шалтгаалж төмрийн хүдрийн үнэ 6 долоо хоног дараалан буурав. БНХАУ-ын эрх баригчдын зүгээс зах зээлд оролцогчдын итгэлийг сэргээхээр оролдож байгаа ч төдийлөн амжилтад хүрэхгүй байна.				
Коксжих нүүрс /СКС ¹ /	223 \$/тн	≈	+7.8	-19.0	+11.4
	БНХАУ-ын үл хөдлөх салбарын уналтаас шалтгаалж гангийн эрэлт сул байгаа ч коксжих нүүрсний үнэ сүүлийн 7 хоногт харьцангуй тогтвортой байна. Гэвч эрэлтийг тогтвортой хадгалах үүднээс цаашид коксжих нүүрс олборлогчид гангийн үйлдвэрүүдээс тавьсан үнэ бууруулах саналыг хүлээж авах төлөвтэй байна. Өмнө нь 2 удаа үнэ бууруулах тохиролцоонд хүрсэн юм. Эдгээр нөлөөгөөр нүүрсний үнэ оны эхнээс 19 хувиар буураад байна.				

¹ БНХАУ-ын зах зээлийн коксжих нүүрсний дундаж үнэ

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

- Bloomberg terminal
- Sxcoal
- Reuters
- <https://www.fao.org/worldfoodsituation/foodpricesindex/en/>
- <https://www.mining.com/copper-price-four-chinese-bear-charts/>
- <https://www.nytimes.com/2024/08/01/world/middleeast/how-hamas-leader-haniyeh-killed-iran-bomb.html>
- <https://www.mining.com/gold-price-on-pace-for-worst-week-since-early-june/>
- <https://www.reuters.com/markets/commodities/iron-ore-outlook-dims-china-inventories-steel-output-fade-russell-2024-08-12/>
- <https://www.federalreserve.gov/monetarypolicy/files/monetary20240731a1.pdf>
- <https://www.reuters.com/markets/europe/bank-england-cuts-rates-16-year-high-will-be-careful-next-moves-2024-08-01/>
- <https://www.cbr.ru/eng/press/keypr/>
- <https://www.reuters.com/markets/asia/china-central-bank-cuts-short-term-policy-rate-2024-07-22/>
- <https://www.reuters.com/markets/rates-bonds/bank-japan-outline-bond-taper-plan-debate-rate-hike-timing-2024-07-30/>
- <https://mongol.cri.cn/2024/07/15/ARTIlrj7sg11HExzq0eKVqkc240715.shtml>
- <https://www.globaltimes.cn/page/202407/1316304.shtml>
- https://www.boj.or.jp/en/mopo/mpmdeci/mpr_2024/k240731a.pdf
- <https://apnews.com/article/japan-economy-rates-boj-yen-e00919b053412fabf7a800ed78a9ad7a>